



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 1403

Пионер толгой

**Хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дэх, 59 дүгээр зүйлийн 59.1.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэж шилжүүлэх, акталж, данснаас хасах журам”-ыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 14 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 оны эхний хагас жилд бэлтгэгдсэн 5 төрлийн 93.992.800 (Ерэн гурван сая есөн зуун ерэн хоёр мянга найман зуу) төгрөгийн хөрөнгийн эзэмшигчийг хавсралтад зааснаар тогтоож холбогдох байгууллагын дансанд бүртгэсүгэй.
2. Хавсралтад заагдсан хөрөнгүүдийн өөрийн байгууллагын дансанд бүртгэж хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг холбогдох журам зааврын дагуу зохион байгуулахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Гантулга), холбогдох байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг “Төсөв санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн бодлогын хороо” (Д.Буян-Өлзий), сумын өмч хамгаалах зөвлөл (Э.Сүглэгмаа)- д үүрэг болгосугай.

ДАРГА  НЭРДЭНЭ-ОЧИР



648801023

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2023 оны ээлжит 14 дүгээр  
Хуралдааны 144 дугаар тогтоолын  
Хавсралт



**ГУРВАНБУЛАГ СУМЫН 2023 ОНЫ ОРОН НУТГИЙН  
ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДСЭН ХӨРӨНГҮҮДИЙГ  
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр	Төсөвт өртөг	Эзэмшигч
1	Иргэний танхим байгуулах	35000000	Засаг даргын Тамгын газар
2	Бэлчээр хашиж хамгаалах	9750000	Засаг даргын Тамгын газар
3	Тохилог гэр (вагончиг худалдан авах)	19000000	Засаг даргын тамгын газар
4	Цахим сургалт ухаалаг хэрэглээ (сургуулийн анги бүрийн ухаалаг дэлгэцтэй болгох)	25242800	Ерөнхий боловсролын сургууль
5	Хүлэмж, холбогдох материал	5000000	Цэцэрлэг
	Дүн	93992800	